

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

№02

Улаанбаатар хот

“Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг хуралдуулах тухай авч хэлэлцээд ТОГТООХ нь:

1. “Талын гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг энэ оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 14.00 цагаас тус компанийн хурлын танхимд хуралдуулахаар, бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөр тасалбар болгохоор тус тус тогтоосугай.
2. Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - “Талын гал” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан
 - “Талын гал” ХК-ийн 2025 оны жилийн санхүүгийн тайланг үндэслэн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, уг ногдол ашгийг тараах талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны цалин, урамшуулал, зардлын төсвийг батлуулах.
3. Компанийн тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг зохих журам, дүрмийн дагуу бүрэн хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга У.Батсуурь, Гүйцэтгэх захирал С.Цэрэндондов нарт даалгасугай.

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



У.БАТСУУРЬ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	“Талын гал” ХК
Хаяг, утас	Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум, 5-р баг, утас: 99119508, 99111569
Хурал хуралдах өдөр, цаг	2026 оны 4-р сарын 30-ны өдөр, 14.00 цагаас
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум, 5-р багийн нутагт орших компанийн хурлын танхимд
Хурлын төрөл	Ээлжит хурал
Хурал зарлагч	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	ТУЗ-ийн 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 02 тоот тогтоол
Олон нийтэд зарлах огноо	2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр
Бүртгэх өдөр	2026 оны 4-р сарын 6-ны өдрөөр тасалбар болгох
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2026 оны 3-р сарын 20-ны өдөр
Хүргүүлсэн огноо	Журмын дагуу
Хурлын даргын нэр	У.Батсуурь
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Ч.Түвшинбаяр, Х.Шинэбаяр, Г.Насанжаргал
Баримт бичгийн жагсаалт	-2025 оны санхүүгийн тайлан -2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан -Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт -ТУЗ-ийн 2026 оны цалин, урамшуулал, зардлын төсөл.
Баримт бичгийн хуудсын тоо	Зохих журмыг мөрдөж гаргана.

Хурал зохион байгуулах комиссын дарга,

ТУЗ-ийн дарга



У.Батсуурь

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

“Талын гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 14:00 цагаас** Сүхбаатар аймаг, Сүхбаатар сумын 5 дугаар багийн нутагт орших тус компанийн хурлын танхимд болно.

Бүртгэлийн өдрийг **2025 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөр** тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Талын гал” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан
2. “Талын гал” ХК-ийн 2025 оны жилийн санхүүгийн тайланг үндэслэн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны цалин, урамшуулал, зардлын төсвийг батлуулах.

Жич:Хурлаас гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт бичигтэй компанийн хурлын танхимд ажлын цагаар ирж танилцана уу.

Хурал зохион байгуулах комиссын утас: **99119508, 99111569**

“Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл

